

**ХОВДИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ШИЙДВЭР, ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

/2016 оны 11 сарын 29-ний өдрийн хурал/

Шийдвэрлэсэн нь:

- ХИС-ийн оюутнуудтай хийсэн уулзалтаас гарсан санал, түүний мөрөөр арга хэмжээг авч ажиллахыг холбогдох дэд захирал Б.Батмөнх, Д.Өрнөхдэлгэр, Т.Одончимэг, ИМТ, бүрэлдэхүүний сургуулиудад үүрэг болгов.
- ХИС-ийн “Тэнхим”-ийн нэршил өөрчлөх, нэгтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулах, хийх ажлын төлөвлөгөө батлуулах тухай асуудлын хүрээнд Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулах. Үүнд: Ажлын хэсгийн ахлагчаар Д.Өрнөхдэлгэр, Гишүүдэд: 3 сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нар, Б.Дүгэрсүрэн /БШТС/, И.Жавхлан /НХУС/, Ц.Оюун /ГХСС/
 - Хэлэлцүүлэг хийх бэлтгэл хангасан байх. Үүнд: Одоо байгаа тэнхимийн хөтөлбөр, оюутан, багш, доктор багшийн тоог тус тус гаргах, Шинээр бий болох тэнхимийн хөтөлбөр, оюутан, багш, доктор багшийн тоог тус тус гаргахыг Д.Өрнөхдэлгэр, З.Бурмаа, Б.Цэрэндаваа, Т.Одончимэг нар үүрэг болгов.
- Гадаад болон дотоодод докторантурт суралцагчдын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай асуудлын хүрээнд ХИС-ийн багш нараас гадаад болон дотоодод докторантурт суралцаж байгаа докторант нартай 2016 оны 12 сарын 01-ний өдөр уулзаж мэдээллийг авсан байхыг Ч.Лхагвасүрэн, Б.Сувданцэцэг нарт үүрэг болгов.
- Ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэн танхайрсан багш нарт 2016 оны 12 сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн цалингийн 20%-аар 3 сар хасах сахилгын шийтгэл ноогдуулахаар шийдвэрлэж хуулийн зөвлөх Ц.Буянбатад үүрэг болгов.
- Зарим багш нарын цалинтай, цалингүй чөлөө, унааны зардал, хүссэн өргөдлийг шийдвэрлэж З.Бурмаа, Б.Цэрэндаваа, Т.Одончимэг Ц.Буянбат нарт даалгав.
- Хичээлийн II байрны номын санд Швейцарь номын санг шилжүүлж, өрөөг нь ХИС-ийн Күнзийн институтын сургалтын үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэв
- Захиргааны зөвлөлийн гишүүдийн анхааралд: Цагийн хүрэлцээ муутай байгаа тул болж өгвөл хичээл орохгүй байх, Захиргааны бодлогын чанартай ажилд илүү анхаарлаа хандуулж ажиллахаар болов.
- Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэхээр шийдвэрлэв. Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 40% нь захиргааны зөвлөлийн гишүүн байна, Бүрэлдэхүүний сургуулиуд 3, 3, салбар сургуулиас 2 хүн байхаар саналаа оруулж ирэхийг З.Бурмаа, Б.Цэрэндаваа, Т.Одончимэг нар хариуцуулав.
- Санхүүгийн албаны дарга Б.Дэлгэрцэцэг, Нягтлан бодогч Д.Энхжаргал, Хуулийн зөвлөх Ц.Буянбат нарын ажилласан хугацааны тайланг сонсож, 2016 оны 12 сарын 01-ний өдрөөс жинхлэн ажиллуулахаар шийдвэрлэв.
- Санхүүгийн албаны дарга Б.Дэлгэрцэцэг, Нягтлан бодогч Д.Энхжаргал, Хуулийн зөвлөх Ц.Буянбат нарын ажилласан хугацааны тайланг сонсож, 2016 оны 12 сарын 01-ний өдрөөс жинхлэн ажиллуулахаар шийдвэрлэв.
- Хичээлийн I байрны өлгүүрчнээр С.Өлзийтогтохыг 2016 оны 11 сарын 14-ний өдрөөс эхлэн ажиллуулахаар шийдвэрлэв.

- Хичээлийн II байрны өлгүүрчнээр ажиллахаар хүсэлт гаргасан О.Оюунцэцэгийн хувьд тус сургуульд үйлчлэгчээр ажиллаж байгаад 2016 оны 06 сард тэтгэвэрт гарсан тул ажиллуулах боломжгүй гэж шийдвэрлэв.
- Хичээлийн 2-р байрны гадна хаягийг зах зээлийн үнэ, ханш судлан дараагийн захиргааны зөвлөлийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Б.Батмөнхөд даалгав.
- Сургалт, аргазүйн байгууллага үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан сургуулийн зүгээс баяр хүргэж, хүндэтгэл үзүүлэхээр шийдвэрлэв.
- Тэтгэврийн насанд хүрсэн багш, ажилчидтай урьдчилан захирал, холбогдох дэд захирал болон, сургуулийн захирлын хамт уулзах, Тэтгэвэрт гарах нас хэтэрсэн 4 хүнд мэдэгдэл өгөөд, хугацааны хувьд ярьж тохиролцохоор шийдвэрлэв.
- Нийгмийн ажилтан арга зүйн тэнхимийн багш, оюутнуудаар ХИС-ийн оюутны байр болон Лицей сургуулийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой нийгмийн судалгааг хийлгүүлэхээр шийдвэрлэв. Судалгааны асуулгад эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэл ханамж, харуул хамгаалалтын талаар тусгахыг Т.Одончимэгт хариуцуулав.
- Холбогдох ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт шинэчлэх, шинээр боловсруулах тухай асуудлыг Холбогдох дэд захирал, Бүрэлдэхүүний сургуулийн захирлууд, Хүрээлэнгийн захирал, Эдийн засагч, Хуулийн зөвлөхөд даалгав.
- Лицей сургуулийн 11^б ангид 12-ын тоосгон ханыг аж ахуйн ажилчдаар 2016 оны 12 сарын 03-аас 2016 оны 12 сарын 04-ний хооронд өрүүлж дуусгахаар шийдвэрлэв.
- Оюутны байрны гадна талбайг камержуулахаар шийдвэрлэв.
- Ховд их сургуулийн Гадаад хэлний сургалтын төв, Солонгос хэлний төв, Күнзийн институттай холбоотой дараах асуудлыг судлан дараагийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Д.Өрнөхдэлгэрт даалгав.
- Тойрох хуудсыг шинэчлэхээр шийдвэрлэв./Загвар, форматыг гаргахыг Б.Батмөнх, Д.Энхжаргал нарт даалгав.

Захиргааны зөвлөлийн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын чиглэлийг гаргасан:

**Б.Болормаа /Хяналт шинжилгээ,
 үнэлгээний мэргэжилтэн/
 Ц.Буянбат /Хуулийн зөвлөх/**

Ховд хот, 2016.12.02